

ТАНИЛЦУУЛГА

Жагсаал цуглаан хийх журмын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн
төслийн тухай

Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхүүдийн нэг нь тайван замаар жагсаал, цуглаан хийх эрх бөгөөд энэхүү эрхийг Монгол улс Үндсэн хуулиараа баталгаажуулж өгсөн. Жагсаал, цуглаан хийхтэй холбоотой процессыг 1990 оны 1 дүгээр сарын 17-нд Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын Тэргүүлэгчдийн 10 дугаар тогтоолоор “Нийслэл хотын гудамж, талбайд олон нийтийн үүсгэл санаачлагаар хурал, цуглаан хийх, жагсаал, ёслол үйлдэх тухай түр журам”-ыг, үүний дараа 1990 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр АИХТ-ээс “БНМАУ-ын хот, суурингийн гудамж, талбайд хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх журмын тухай” №86 дугаар зарлигийг мөн баталсан байдаг. Улмаар 1994 онд “Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль”-ийг УИХ-аас баталж, 2005 онд холбогдох өөрчлөлтүүдийг хийсэн.

Жагсаал, цуглаан хийх журам үе шаттайгаар сайжран, дэвшсээр ирсэн боловч сүүлийн үед болж буй үйл явдлуудаас харахад технологийн дэвшил, нийгмийн хөгжилтэй холбоотойгоор уг хууль нь цаг үеэсээ хоцрогдсон, иргэдийнхээ эрхийг боомилсон агуулгууд шингээсэн байгаа болох нь харагдаж байна. Мэдээллийн ялгаатай байдал багасахын хэрээр шийдвэр гаргалтанд нөлөөлөх иргэдийн оролцоо үлэмж нэмэгдсэн нь зарим асуудлуудыг хэлэлцүүлэгт бэлтгэх, хэлэлцэхтэй зэрэгцэн иргэд эсэргүүцлээ илэрхийлэх нь нэмэгдэж буй ч хуульд ажлын 3 хоногийн өмнө жагсах мэдэгдэлээ холбогдох албан тушаалтанд ирүүлдэг нь жагсаал, цуглааныг санаачлагч, зохион байгуулагчийг нь зөрчлийн хуулиар торгуулах үндэслэл болж байна.

Анх батлагдсан 1994 оны хуульд жагсаал, цуглаан зохион байгуулахтай холбоотойгоор зөвшөөрөл авдаг байсныг 2005 онд мэдэгдэл болгон өөрчилсөн нь хуулийн хэрэглээн дээр энэ нь зөвшөөрлийн агуулгатайгаар хэрэгжиж буйг нэг мөр цэгцлэх асуудал ч үүсч байна. Ийм учраас дээрх өөрчлөлтүүдийг тусган “Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачлан өргөн барьж байна.

Хуулийн төслийг боловсруулж эхлэхтэй зэрэгцэн өөрийн сошиал хуудсаар санал асуулгын программ ашиглан иргэдээс санал авсан бөгөөд ирүүлсэн саналуудыг товьёог үүсгэн хавсаргасан болно. 2021 оны 11 сарын 23-ны өдөр <https://lawforum.parliament.mn/> сайтад боловсруулсан хуулийн төслийг байршуулсан бөгөөд ямар нэгэн санал ирээгүй болно.